



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

20~~25~~ оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/16

Даланзадгад сум

“Эрүүл элэг хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- Хүн амын дунд гепатит вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын хяналт тандалтыг сайжруулж нас баралт, өвчлөлийг бууруулах зорилготой “Эрүүл элэг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.
- Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

4625010046

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн
4/16 дугаар тогтоолын хавсралт

“ЭРҮҮЛ ЭЛЭГ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
(2025-2028 он)

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл дадал хэвшилт төлөвшүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Өсөлттэй Өмнөговь” үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрийн дараах хэсгүүдэд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, хүн амын дунд гепатитын вирусийн халдвартыг эрт илрүүлж, үзлэг оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд бүрэн хамруулж, гепатитын вирусийн шалтгаант өвчлөл, эндэгдлийт бууруулах зорилт арга хэмжээ тусгагдсан. Тухайлбал: “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 2.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1 дэх хэсэгт “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх” чиглэл тусгагдсан.

Өмнөговь аймаг нь 2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн ам 76989 хөдөлгөөнт хүн ам 70,000 гаруй болсон бөгөөд суурин хүн амын 50,1% нь эрэгтэй, 49,9 % нь эмэгтэй эзэлж байна.

Өмнөговь аймгийн хүн амын дундаж наслалт 2023 оны байдлаар 73,4 байгаа нь улсын дунджаас (71.5) 1.9 жилээр өндөр байгаа ба сүүлийн 20 жилд 7,8 жилээр өссөн байна. Дундаж наслалтын хүйсийн зөрүү 8,5 жил байгаа нь улсын дунджаас (9,2) 0,7 жилээр бага байгаа ба эрэгтэйчүүдийн дундаж наслалт 69,4, эмэгтэйчүүд 77,9 байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар 100974 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6976 тохиолдолоор буурсан байна. Нийт өвчлөлийн 71,7% нь шинэ өвчлөл байна. Өвчлөлийн тэргүүлэх шалтгаан нь амьсгалын тогтолцооны өвчин, хоол шингээх эрхтний өвчин, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, шээс бэлгэсийн тогтолцооны өвчин, мэдрэлийн тогтолцооны өвчин эмгэг болж байна.

Жилийн эцсийн байдлаар нас баралтын 339 тохиолдол бүргэгдсэн ба 20.9% нь хорт хавдар, 12.9% нь осол гэмтлийн нас баралт, 5.9% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдлээр нас барсан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилийн дунджаар жилд дунджаар 112 хавдрын шинэ тохиолдол бүртгэгдэж, 76 тохиолдол нас бардаг. Энэ нь 10000 хүн амд 16.5 өвчлөл оношлогдож, 11 нас баралт жилдээ тохиолдож байна.

Хорт хавдрын тохиолдол 2024 онд 93 тохиолдол бүртгэгдсэн нь сүүлийн 10 жилийн дунджаас 29 тохиолдолоор бага байна. Шинээр оношлогдсон хавдрын 88% нь T3, T4 шатандаа хожуу оношлогдсон ба 2.6% нь 1-19 насны хүүхэд, 33.1% нь 20-54 насны залуучууд, 64.2% нь 55-с дээш насны хүмүүс байна. Мөн нас баралтын тохиолдол нэмэгдэх хандлагатай байгаа ба 2024 онд 81 тохиолдол бүртгэгдсэн нь 10 жилийн дунджаас 3 тохиолдолоор өндөр байна.

10000 хүн амд ногдох хорт хавдрын шинэ өвчлөлөөрөө улс аймгийн дунджаас бага байдаг ба сүүлийн 10 жилийн дунджаар улсын дунджаас (19.7) 3-р, аймгуудын дунджаас (21.8) 5.1-р бага хэдий ч сүүлийн жилүүдэд тасралтгүй нэмэгдэж байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд хавдрын тэргүүлэх шалтгаанд элэгний хавдар зонхилж байгаа ба ходоод, умайн хүзүү, улаан хоолой, бөөрний хавдар удаах байруудад байна. 10000 хүн амд элэгний хавдрын тохиолдол нь 2023 оны байдлаар 6.3 байгаа ба улсын дунджаас 0.7 промиль, аймгуудын дунджаас 2 промилээр бага байна.

Элэгний хавдрын өвчлөл нь 2003-2008 онуудад нэлээд нэмэгдэж 6.8-д хүрсэн ба 2011 он хүртэл буурч (3.4), 2011-2018 онуудад тасралтгүй нэмэгдэж 13.2 хүрч байсан. 2019 оноос буурах хандлагатай байгаа боловч жил тутамдаа туштай буурахгүй байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд “Эрүүл элэг” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж гепатит вирусийн халдвартын эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 49989 /2021-2024/ иргэнийг эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд хамруулж, 0.9% буюу 476 нь С вирустэй, 1.07% буюу 537 нь В вирустэй тохиолдлыг шинээр илрүүлэн эрүүл мэндийн байгууллагын хяналтад авсан.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвд молекул биологийн шинжилгээний нэр төрөл, хучин чадлыг сайжруулан гепатит вирусийн идэвхжил тоолох шинжилгээг хийж эхэлсэн. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр хөтөлбөрийн нийт хугацаанд 50000 гаруй иргэнд сургалт, сурталчилгаа өдөрлөг зэрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, В гепатитын халдвараас сэргийлэх зорилгоор сайн дурын дархлаажуулалтын арга хэмжээнд 5411 хүн тун вакцин хийгдсэн байна.

Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, лаборант, дүн бүртгэгч, жолооч нар зэрэг нийт 220 гаруй эмч, мэргэжилтэн сургаж мэргшүүлсэн. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулснаар шинэ технологи нэвтрүүлэх, эмчилгээ оношилгооны үр дүнг сайжруулахад чухал ач холбогдолтой байсан.

“Эрүүл элэг” хөтөлбөр нь амжилттай хэрэгжиж олон нийтэд чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг нэмэгдүүлэн, эрүүл мэндийн салбарын урьдчилан сэргийлэлт, эмчилгээ болон өвчтөний хяналтыг сайжруулах чиглэлээр чадавхыг бий болгож, лаборатори болон тандалтын системийг бэхжүүлэн сайжруулах чиглэлээр богино хугацаанд үр дүнтэй хэрэгжсэн.

Сүүлийн жилүүдэд 10,000 хүн амд ногдох хавдрын өвчлөл нэмэгдэж байна. Энэ нь хүн амын тоо жилээс жилд нэмэгдэх, эрт илрүүлэг оношилгоо, шинжилгээний тоног төхөөрөмжийн чанар хүртээмж, эрт илрүүлгийн үр дүнтэй шууд хамааралтай. Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн 2021 оноос хойш хавдрын нас баралт 10.000 хүн амд 0.8 промилээр буурсан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд хавдрын тэргүүлэх шалтгаанд элэгний хавдар зонхилж байна. 10,000 хүн амд элэгний хавдрын тохиолдолд нь 2024 оны байдлаар 4,6 промиль байгаа ба улсын дунджаас 0,7-р, аймгуудын дунджаас 2-р тус тус бага түвшинд байна.

Хүн амын өвчлөл нас баралтын шалтгаан болж байгаа элэгний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагын эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгооны чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчлэн эрүүлжүүлэх, эмчилгээний хяналтыг сайжруулах, дархлаажуулалтыг эрчимжүүлэх, иргэдэд мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулдаг тогтолцоог бэхжүүлэхэд “Эрүүл элэг” хөтөлбөр нь чухал ач холбогдолтой юм.

Хөтөлбөрийн үндсэн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн өнөөгийн ололт амжилтад дун шинжилгээ хийж, цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ололт амжилт, сургамж дээрээ суурилан хүн амын дунд гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж, оношлох, эмчилгээнд бүрэн хамруулж, халдвартархах эрсдэлийг бууруулан, гепатит вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын хяналт тандалтыг сайжруулж нас баралт, өвчлөлийг бууруулахад онцгой анхааран ажиллах шаардлага бидэнд тулгарч байна.

Аймгийн Засаг даргын “Өсөлттэй Өмнөговь” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.4 дэх заалтад Элэгний шалтгаант өвчлөл нас баралтыг бууруулах зорилгоор “Эрүүл элэг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээг өмнөх туршлага, чадавх дээрээ тулгуурлан хэрэгжүүлж, хөтөлбөрийг ирэх 2025-2028 онд илүү үр дүнтэй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго.

Хүн амын дунд гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж, оношлох, эмчилгээнд бүрэн хамруулж, халдвартархах эрсдэлийг бууруулан, гепатит вирусийн шалтгаант элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын хяналт тандалтыг сайжруулж нас баралт, өвчлөлийг бууруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилт.

Зорилт 1: Хүн амыг гепатитын вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх эрүүл мэндээ хамгаалах, дэмжих зөв дадалд иргэдийг хэвшүүлэх, дархлаажуулалтын арга хэмжээг өргөжүүлэн хүн амын халдварт авах эрсдэлийг бууруулна.

Зорилт 2: Гепатитын В, С, Дельта вирусийн халдварын тандалт, илрүүлэг, эмчилгээг сайжруулан хүн амд чанартай тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

Зорилт 3: Элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж төр, териин бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Өмнөговь аймгийн нийт хүн ам болон хөдөлгөөнт хүн ам

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1.1. Амьдралын хэв маяг, зан үйлээс хамааран гепатитын вирусийн халдварт өртөх, эрсдэлтэй болон нийт хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг зохион байгуулах;

5.1.2. Θсвөр үе оюутан залуучууд, олон нийтийн эрүүл мэндийн ажилтнуудаар дамжуулан хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

5.1.3. Гепатитын В, С вирусийн халдварын тохиолдол шинээр бүртгэгдэх бүрд халдвар дамжих замыг тодорхойлсон тандалт, эрдэм шинжилгээний судалгааны ажлыг зохион байгуулах;

5.1.4. Хумс засах, шивээс хийх, чих цоолох зэрэг гоо сайхны үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгж, байгууллагад мөрдөх халдвартгүйтгэл, ариутгалын зааврыг мөрдүүлж хэвшүүлэх, хяналт тавих;

5.1.5. Насанд хүрэгчдийг өөрийн хүсэлтээр болон эрхэлж байгаа ажил, үйлчилгээний онцлог, ойрын хавьтлуудыг гепатит В вирусийн сайн дурын дархлаажуулах арга хэмжээг зохион байгуулах, вакцины хангамжийг нэмэгдүүлэх, дархлал тогтцын түвшнийг судлах, хамрагдалтад хяналт тавих;

5.1.6. Гепатит В вирусийн халдвартай эхээс хүүхдэд халдвар дамжихаас сэргийлэх зорилгоор төрсний дараа 24 цагийн дотор нярайд гепатитын В вирусийн эсрэг вакцин иммуноглобулин тарих;

5.1.7. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх аюулгүй тарилга цусны аюулгүй байдлыг сайжруулах гепатитын вирусийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах чиглэлээр эрүүл мэндийн ажилтныг чадавхжуулах, дэмжлэгт хяналт хийх.

5.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.2.1. Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчинеэс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ оношилгоог зохион байгуулах;

5.2.2. Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд тандалт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаар тасралтгүй сургалт зохион байгуулах, хүний нөөцийг нэмэгдүүлэх;

5.2.3. Лабораторийн чадавхыг сайжруулах, гепатит В, С, Дельта вирусийн ачаалал тодорхойлох шинжилгээг тогтмолжуулах;

5.2.4. Эрүүл мэндийн байгууллагуудын гепатитын вирусийн халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэгт шаардагдах, тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, урвалж бодисоор хангах;

5.2.5. Гепатитын вирусийн халдвартай, вирусийн тархалт ихтэй эрсдэл өндөртэй хүн амын бүлгээс эхлэн вирусийн эмчилгээнд хамруулах, эрүүл хатуурлыг хянах, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

5.2.6. Эхээс хүүхдэд гепатитын В, С вирусийн халдвар дамжихаас урьдчилан сэргийлэх, тандалт хяналтыг сайжруулах.

5.3. Хөтөлбөрийн З дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.3.1. Элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

5.3.2. Орон нутагт элэгний хавдрын өвчтэй хүмүүст үзүүлэх хими, бай, хөнгөвчлөх эмчилгээ болон нийгэм сэтгэл зүйн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.3.3. Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүр цирроз, хорт хавдартай иргэдэд үзүүлэх гэрийн идэвхтэй хяналт, тусlamж үйлчилгээг сайжруулах чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжих хугацаа
Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

7.1.2. Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж,

7.1.3. Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн

8.1. Элэгний хорт хавдрыг эрт илрүүлэн эмчлэх нөхцөл бүрдсэнээр хорт хавдрын шалгаант нас барагт буурч, хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.

8.2. Хүн амын бүлэг бүрд тохирсон, хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулгадж, гепатитын вирусийн халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд хувь хүний оролцоо нэмэгдэнэ.

8.3. Дархлаажуулалт, эрт илрүүлгийн хамралт нэмэгдсэнээр өвчлөлийн түвшин буурна.

8.4. Өвчлөлийг эрт илрүүлснээр эмчилгээг цаг алдалгүй хийлгэн хүндрэлзээс сэргийлж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулж, амьдралын чанарыг сайжруулна.

8.5. Эрүүл мэндийн байгууллагын эмчилгээ, оношилгоо шинжилгээнд техник технологи, эм, урвалжийн шинэчлэл хийгдэж, гепатитын вирусийн шинжилгээ, оношилгоог, эмчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Ёс. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүр эрүүл мэндийн төвүүд аймгийн Эрүүл мэндийн газар, харьяа сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнаж, Эрүүл мэндийн газар хяналт тавьж ажиллана.

9.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна

9.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд суурилсан явцын болон хөндлөнгийн үнэлгээг жил бүр хийлгэнэ.

9.4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Арав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

10.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Нийгмийн бодлогын хэлтэс) хэрэгжүүлнэ.

10.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнаж ажиллах чиг үүргийг Эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэнэ.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

11.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үр нөлөөний болон үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2024 оны эрүүл мэндийг үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглана.

11.2. Эрүүл мэндийн газрын статистик мэдээллийг үндэслэн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тооцно.

Эрүүл элэг хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт		Хүрэх түвшин			
			2024	2025	2026	2027	2028	
1.	Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 15-аас дээш насны иргэдийн тоо	Бодит тоо	18015	18915	19860	20844	21886	
2.	Тухайн жилд эрт илрүүлэгт хамрагдсан хүн амын дундах гепатит В вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол /10,000 хүн амд/	Промиль	3,7	3,6	3,5	3,4	3,3	
3.	Тухайн жилд эрт илрүүлэгт хамрагдсан гепатит С вирусийн өвчлөлийн шинэ тохиолдол /10,000 хүн амд/	Промиль	2	1,9	1,8	1,7	1,6	
4.	Гепатитын В вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдах заалттай иргэдээс хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Бодит тоо	75	90	190	290	395	
5.	Гепатитын С вирусийн архаг халдвартай гэж оношлогдсон иргэдээс вирусийн эсрэг эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо	Бодит тоо	81	85	90	95	100	
6.	Гепатитын С вирусийн эсрэг эмчилгээний горим бүрэн дуусгасан өвчтөнүүдээс бүрэн эдгэрсэн иргэдийн хувь	Хувь	54,3%	60%	65%	70%	75%	
7.	Гепатит делта вирусийн эсрэг эмчилгээг нэвтрүүлж эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Тоо	-	-	7	10	15	
8.	Гепатитын В вирусийн архаг халдвартай эхээс төрсөн нярайг 12 цагийн дотор В вирусийн эсрэг вакцин, иммуноглобулиныг хавсран хэрэглэсэн хувь	Хувь	90%	100%	100%	100%	100%	
9.	В гепатитын сайн дурын дархлаажуулалтад хамрагдсан 18-с дээш насны иргэдийн тоо	Тоо	500	600	700	800	900	
10.	Гепатитын В, С, Дельта вирусийн шалтгаант элэгний хорт хавдар 10,000 хүн амд	Промиль	4,2	4,1	4	3,9	3,8	
11.	Гепатитын В, С, Дельта вирусийн халдвараас үүдэлтэй элэгний хорт хавдрын шалтгаант нас бааралтын түвшин (10,000 хүн амд)	Промиль	4,1	4	3,9	3,8	3,7	

12.	Нийгмийн эрүүл мэндийн сургалт нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн хувь	Хувь	80%	85%	90%	95%	100%
13.	Хөтөлбөрийн хэрэгжилт хувь	Хувь	92,6%	94%	95,4%	96,8%	98%
14.	Элэгний хатуурлын хяналтын хувь	Хувь	0	-	70%	75%	80%

oOo